

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УТХО - УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ОНТ – ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

АЗДТГ – АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТЗУХ – ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

ХЭЗХ – ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

НБХ – НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ХОХБТХ – ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

СТСХ – САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

ААН – АЖ АХУЙН НЭГЖ

ЦГ- ЦАГДААГИЙН ГАЗАР

БСУГ- БОЛОВСРОЛ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

НД – НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

ХХҮҮГ- ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ХХААГ- ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

БОАЖГ- БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ЭМГ- ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

ОБГ- ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

ГХБХБГ- ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

ГБХЗХГ- ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

МЭГ- МАЛ ЭМНЭЛЭГИЙН ГАЗАР

ШША – ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

УЦУОШТ – УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

СУБ – СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГА

ТХДЖТ – ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖҮЖГИЙН ТЕАТР

ТТХТ – ТЭНГЭРИЙН ТЭМДЭГ ХҮҮХДИЙН ТЕАТР

МСҮТ – МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

БТСГ – БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ГХУСАЗЗ–ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛ

ОНӨҮГ – ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

БЗӨБЦТС - БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ

ТӨХК – ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЦТСС – ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ САЛБАР

ШҮГ – ШУУДАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ОУБ – ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

ЭТИС - ЭРДЭС БАЯЛАГ ТҮҮХИЙ ЭДИЙН ИЖ БҮРЭН САНААЧЛАГА

ЭМДТ- ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

ЦШ-ЦЭРГИЙН ШТАБ

## **ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА**

**Зорилго. 3** Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн, хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.03 хувиар нэмэгдүүлнэ.

### **Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл**

Зорилго 3.1 Нийгмийн даатгалын хамрагдалтыг 2020 онд эдийн засгийн идэвхтэй хүн амын 52,4 хувь байсныг 2025 онд 60,0 хувь болгоно.

**Зорилт 3.1.1** Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 2020 онд 11198 байсныг 2025 онд 12218-д хүргэнэ.

3.1.1.1 Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

3.1.1.2 Нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 3.1.2** 2019 онд нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар 10 хувь нь авч байсныг 2025 онд 90 хувиар нэмэгдүүлнэ.

3.1.2.1 Нийгмийн халамжийн үйлчилгээ авагч иргэдийг нэрийн дансжуулж, цахим карттай холбоно.

3.1.2.2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн 60 хувь нь хүсэлтийг цахимаар авдаг болно.

### **Орлогод нийцсэн орон байр**

Зорилго. 3.2 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн орон сууц 2020 онд 108 өрх хангаснаас 2025 онд 256 өрхийг хангана.

**Зорилт 3.2.1** Орон сууцжуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.2.1.1 Аймгийн төвийн "Түмний хороолол", "Хаус хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө", ажлын зургийг батлуулна.

3.2.2. Сумдад орон сууцны газар олгон барилга байгууламжийг ашиглалтад оруулна.

### **Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес**

Зорилго 3.3 2019 оны Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 2025 он хүртэл 2 хувиар нэмэгдүүлнэ.

**Зорилт 3.3.1** 2019 оны ажиллаж байгаа 22040 иргэний байнгын ажлын байрыг 660-аар нэмэгдүүлнэ.

3.3.1.1 Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулж 199 ажлын шинэ байр бий болгоно.

3.3.1.2 Бүртгэлтэй ажил хайж байгаа иргэдээс сул чөлөөтэй байнгын ажлын байранд 201 иргэнийг зуучилна.

3.3.1.3 Хөдөлмөр эрхлэх төсөл 260 иргэнийг хамруулж байнгын ажлын байртай болгоно.

### **Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг**

Зорилго. 3.4 Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдын А, В үнэлгээтэй иргэд 2019 онд 21.9 хувьтай байсныг 2025 онд 36.9 хувьд хүргэнэ.

**Зорилт 3.4.1 Нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчид 2019 онд 25193 байсныг 2025 онд 28833-д хүргэнэ.**

3.4.1.1 Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгчдийн хүрээг өргөжүүлнэ.

3.4.1.2 Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг дэмжиж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

3.4.1.3 Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, спортын талбайг байгуулна.

3.4.1.4 Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулна.

3.4.1.5 Сагсан бөмбөгийн 3x3 спортын төрлийг орон нутагт дэмжин хөгжүүлнэ.

3.1.4.6 "Бага олимп" наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

**Зорилт 3.4.2 Ахмад настнуудын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношлогоонд хамрагдалт 2019 онд 37.2 хувь байгааг 2025 онд 70 -аас дээш хувьд хүргэнэ.**

3.4.2.1 Ахмадад ээлтэй сум, баг, байгууллагыг журмын дагуу шалгаруулна.

3.4.2.2 Ахмад настнуудыг нас,бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулна.

3.4.2.3 Ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, ахмадын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

### **Газрын харилцаа**

Зорилго.3.5 Орон нутгийн геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаас 2020 онд 3

масштабын байр зүйн зургийг ашигладаг байсан бол 2025 онд 4 масштабын байр зүйн зургаар бүрэн хангана.

**Зорилт 3.5.1 1:25000 нарийвчлал бүхий шинээр боловсруулагдсан зураг зүйг үйл ажиллагаанд нэвтрүүлэн хүлээн авна.**

3.5.1.1 Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарт 2019 онд 1:100000 зураг зүйг ашигладаг байсныг 2025 онд 1:25000 нарийвчлал бүхий шинээр боловсруулагдсан зураг зүйг 2025 онд үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.